



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/47

Мэргэн хошуу

**Тээврийн хэрэгслийн татвар
хураалт, техникийн хяналтын үзлэг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай" хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.10, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд Автотээврийн болон өөрөө явагч албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг үндэслэн Автотээврийн хэрэгслийн татвар хураалтыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2.Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Амарболд (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: С.Билгүүнбүүвэй (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Н.Цэрэнжав (1 дүгээр багийн Засаг дарга)

Э.Чулуунхүү (2 дугаар багийн Засаг дарга)

А.Пунцагдорж (3 дугаар багийн Засаг дарга)


С.Ууганбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)

3.Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийг холбогдох хууль, журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулан, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Амарболд)-д даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТБОЛД



D:\bichig hereg\2025 он\ЗД захирамж.docx